Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биет бус хөрөнгийн элэгдлийг тооцож нягтлан бодох бүртгэлд тусгах, дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн чанарын менежер Б.Наранцэцэг, аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Ч.Мөнхбулган нар хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ..

- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, хасах,
- Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох,
- Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах,эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулах, тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу олгох.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын дотоод хяналтын мэргэжилтэн 2020 онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон шилэн дансны мэдээлэлд дотоод аудит хийгээгүй байна.

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,303,235.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,032.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг, өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 655,574.1 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	13,990.6	13,990.6
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	4,687.1	4,858.7	171.6
Үндсэн хөрөнгө	33,943,182.4	33,273,446.1	(669,736.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>33,947,869.5</b>	<b>33,292,295.4</b>	<b>(655,574.1)</b>
Нийт өр төлбөр	1,050.0	1,050.0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	33,946,819.5	33,291,245.4	(655,574.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>33,947,869.5</b>	<b>33,292,295.4</b>	<b>(655,574.1)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13,990.6 мянган төгрөг болж нэмэгдсэн байна.

Үүний шалтгаан нь Замын-үүд чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах 2020 онд зохион байгуулсан дуудлага худалдаанд оролцож шалгарсан нэр бүхий 13 аж ахуйн нэгж, иргэний дэнчингийн 13,990.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлүүлээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,858.7 мянган төгрөг болж, 171.6 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 179.7 мянган төгрөгөөр буурч, хангамжийн материал 351.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна

Бараа материалын дансанд 2020 онд харьяа байгууллагууд болон захиалагч байгууллагад шилжүүлээгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 33,292,295.5 мянган төгрөг болж 669,736.3 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2019 оны 207 дугаар тогтоол, Хил хамгаалах ерөнхий газар, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Хилийн 0119 дүгээр анги /ТӨААТҮГ/-ын хамтарсан гэрээг үндэслэн “замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн 1.999.998.6 мянган төгрөгийн дуусаагүй барилгыг бүртгэж, 2,669,734.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 1,050.0 мянган төгрөг байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн 1,050.0 мянган төгрөгийн орлого байна.Энэ нь Тэс Петролиум ХХК-аас орсон Чөлөөт бүсийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1-д заасны дагуу хөнгөлөгдөх газрын төлбөр байна. Энэ нь тухайн байгууллага

хуулийн хөнгөлөлт дуусахаар газрын төлбөр төлж эхлэх ба суутган тооцно гэж тайлбар өгсөн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 33,291,245.4 мянган төгрөг болж 655,574.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны орлого үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үйл ажиллагааны зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,959,859.6 мянган төгрөгөөр буюу 92 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хөрөнгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлого байна. Энэ нь “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн 1,999,998.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, газрын төлбөр болон бусад орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 2,344,989.1 мянган төгрөгөөр буюу 180 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, ашиглалтын зардал байна.

Батлагдсан орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал хэмнэгдсэн, Замын-Үүдийн шинэ боомтыг шинэчлэх ажлын хүрээнд хилийн мэргэжлийн албадыг Замын-Үүдийн чөлөөт бүсийн байранд түр хугацаагаар байрлуулан ажиллуулах болсон тул ашиглалтын зардал нэмж төсөвлөгдөн зарцуулагдсантай холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 845,905.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захриагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт зарлагыг 25,373.6 мянган төгрөгөөр бууруулж 820,531.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлт гарсан зардал хөрөнгийн санхүүжилт, ашиглалтын зардлууд байна. Засгийн газрын 2019 оны 207 дүгээр тогтоолоор баригдах “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн ажлын санхүүжилт 2,000,000.0 мянган төгрөгөөр, Замын-Үүдэд шинэ боомтын байр баригдаж дуусах хүртэл Замын-Үүдийн мэргэжлийн байгууллагууд тус байгууллагын ажлын байранд нүүн ажиллах болсон тул ашиглалтын зардлыг 300,000.0 мянган төгрөгөөр нэмж баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 820,531.5 мянган төгрөгийн санхүүжилт, хөрөнгийн санхүүжилтээр 1,999,998.6 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 172,120.7 мянган төгрөг, нийт 2,992,650.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 333,678.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 641,305.8 мянган төгрөг буюу 78.2 хувьтай байгаа нь цалинтай холбоотой зардлыг 74,768.8 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 109,426.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь батлагдсан орон тоо 8 хүнээр дутуу байгаа нь цалинтай холбоотой зардал, Замын-Үүд дэх чөлөөт боомтын үйл ажиллагаа ковид19 цар тахалтай холбоотой түр хугацаагаар зогссоноос ашиглалтын зардал дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 8,941.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 6,063.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,877.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайланд тусгасан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 156 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл, 25,960.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-			-
Албан шаардлага	-	-	-	-			-
Зөвлөмж	1	-	1	-			100.0
Нийт дүн	1	-	1	-			100.0

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,409.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,990.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6,418.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 13,990.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 13,990.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ.

1. Замын-Үүд чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах 2020 онд зохион байгуулсан дуудлага худалдаанд оролцож шалгарсан нэр бүхий 13 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний дэнчин 13,990,6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээлэл хугацаа хоцроосон, 3 мэдээлэл байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 6,418.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Засгийн газрын 2019 оны 207 дүгээр тогтоолоор Хил хамгаалах ерөнхий газар, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Хилийн 0119 дүгээр анги /ТӨААТҮГ/-ын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр хамтарсан гэрээний дагуу “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн ажлыг хийж гүйцэтгэхэд 2019 онд 999,999.5 мянган төгрөг, 2020 онд 1,999,998.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэл хийгдэн тус албаны дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн дээрх ажлын явцад холбогдох журмын дагуу хяналт тавьж, санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлэн ажиллахыг Шадар сайдын 2019 оны ЗГ-2/657 дугаар албан бичгээр чиглэл болгосон байна.

Тус албаны дансаар гүйлгээ хийж, санхүүгийн тайланд тусгагдсан дээрх ажлын гүйцэтгэлийн талаарх баримт материал, түүнийг дэмжих нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материал байхгүй, “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем” нийт 10,751,000.0 мянган төгрөгийн өртөгтэй, нууцад хамааралтай бөгөөд Хил хамгаалах ерөнхий газрын хөрөнгө болно гэж тайлбарласан.

Үүнээс шалтгаалан Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн алба нь санхүүжилтийг хийхдээ ажлын гүйцэтгэлд хяналт тавих боломжгүй, түүнийг дэмжих нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материал байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хууль болон, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хүндрэлтэй байна. Иймд цаашид дараах асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-д цаашид хийгдэх хөрөнгийн санхүүжилтийг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх
- “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн 2,999,998.1 мянган төгрөгийн дуусаагүй барилгын хөрөнгийг Хил хамгаалах ерөнхий газарт балансаар шилжүүлэх
- “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн 2,999,998.1 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлд нууцын асуудал хариуцсан нэгж хяналт тавих.



#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Худалдан авалт болон гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6,400.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэл болон ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилт хангалтгүй, зардлын хэтрэлт гарах, дотоод хяналт сул.

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн болон ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилтийг хангаж худалдан авч байгаа бараа, ажил үйлчилгээнд гэрээ байгуулан ажил гүйлгээг хийж байх, дотоод хяналтыг сайжруулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

##### **2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Биет бус хөрөнгө болох программ хангамжид 18.4 мянган төгрөгийн элэгдлийг байгуулаагүй, зардалд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-ын "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ". 14.4.6. Бүх зардал гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.35-ын "...Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө." гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл: Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцон зардалд тусгаагүй, хөрөнгийн үнэ буруу тооцогдох, орлого үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хуулийн заалт хэрэгжихгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийг бүрэн тооцож зардалд тусгаж, цаашид алдаа гаргахгүй, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үндсэн хөрөнгийн элэгдлийг заавар журмын дагуу тооцож, зардалд тусгах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2021.2.15</b>	Аудитын нэр: <b>Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/318/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Газрын дуудлага худалдааны дэнчингийн үлдэгдэл төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй	13,990.6	Төлбөрийн акт	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	А.Энхзул С.Эрдэнэбаатар
2	Шилэн дансны мэдээллээс 2 мэдээлэл хугацаа хоцорсон, 3 мэдээлэл байршуулаагүй	0.00	Албан шаардлага	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	А.Энхзул С.Эрдэнэбаатар
3	Баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд хуулийн дагуу гэрээ байгуулж ажиллаагүй, гэрээний заалтад төлбөрийн тооцоолол, мөнгөн дүн байхгүй	6,400.0	Зөвлөмж	Захирагч, Ерөнхий нягтлан бодогч	А.Энхзул С.Эрдэнэбаатар
4	Биет бус хөрөнгө програм хангамжид элэгдлийн зардал тооцож зардалд тусгаагүй.	18.4	Зөвлөмж	Захирагч, ерөнхий нягтлан бодогч	А.Энхзул С.Эрдэнэбаатар
5	Дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй байна.	0.00	Албан шаардлага	Захирагч, ерөнхий нягтлан бодогч	А.Энхзул С.Эрдэнэбаатар
<b>ДҮН</b>		<b>20,409.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 58/A0160059

Улаанбаатар хот

СМГ-2021/318/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаанд оролцож шалгарсан нэр бүхий 13 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний дэнчингийн 13,990,600.00 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Харилцах дансны үлдэгдэл 13,990,600.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны Бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга Ж.Баатарсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Эрдэнэбаатар нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Р.ЦОЛМОН

А.ЦЭРЭНЧИМЭД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 216/АО160059  
САГ-2021/318/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны мэдээлэлд оруулбал зохих 161 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 25,960.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.6 “Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан”-г дараа жилийн 8 дугаар сарын 25-ны дотор, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр гүйлгээний утга, хүлээн авагчийн нэр, 7 дугаар зүйлийн 7.1.3-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга Ж.Баатарсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Эрдэнэбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Р.ЦОЛМОН

А.ЦЭРЭНЧИМЭД





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 215/А0160059

Улаанбаатар хот

СЭГ-2021/318/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны дотоод хяналтын мэргэжилтэн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг сайжруулан байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны Бүртгэл санхүү хэлтсийн дарга Ж.Баатарсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Эрдэнэбаатар нарт даалгав

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Р.ЦОЛМОН

А.ЦЭРЭНЧИМЭД





